

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 10
1. Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал	4 – 10

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 3 дугаар сарын 30-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: О.Алтангэрэл, Г.Уянгахишиг;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ц.Даваасүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа;
Тасалсан: Ж.Баярмаа, Л.Гантөмөр, Т.Доржханд, Э.Одбаяр,
Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгэрэл.*

Нэг.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Ө.Шижир нарын тавьсан асуултад Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 0
Бүгд: 20
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 09 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 23 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Ирц хүрсэн байна. Хуралдаанаа эхэлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдөр Байнгын хороо 3 удаа хуралдана. Орж гараад. Тийм учраас ирцийг одоогийнхоо ирцээр явна.

Тийм учраас бас Эдийн засгийн байнгын хороотой хамтарсан хуралдаан 11.00 цагаас болно. Үдээс хойш ахиж хуралдана гээд. Тийм учраас гишүүдийг бас Байнгын хорооныхоо хуралдаанд идэвхтэй оролцохыг хүсье.

Байнгын хорооны хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилигийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Номин, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа гэсэн нийтдээ 20 гишүүн ирсэн байна.

Хуралдааны ирц 62.5 хувьтай байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/
Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал

Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэж эхэлъе.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлд 12.1 Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд түүнийг хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.

12.2.1.Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан гэж заасан байдаг.

Ингээд Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулна.

Н.Учрал даргын микрофоныг.

Н.Учрал: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга,

Эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ням-Осорын Учрал миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3-д заасны дагуу Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс нэр дэвшин гишүүдийн 82.5 хувийн саналаар сонгогдон 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн Монгол Улсын Их Хурлын даргаар ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь олонх болсон Монгол Ардын намын Бага хурлаас Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх улс төрийн шийдвэр гарлаа.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчмын дагуу Ням-Осорын Учрал миний бие төрийн тасралтгүй, тогтвортой үйл ажиллагааг хангах, парламентын дархлааг хадгалан хамгаалах, улс орны язгуур эрх ашгийг эн тэргүүнд тавих үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас өөрийн саналаар чөлөөлөгдөх хүсэлтээ үүгээр гаргаж байна.

Хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг эрхэм гишүүд Та бүхнээс хүсье.

Ц.Сандаг-Очир: Хүсэлттэй танилцлаа.

Улсын Их Хурлын даргын хүсэлттэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Асуулт, үгээ цугтаа явчихъя.

Д.Энхтуяа гишүүнээр тасаллаа. Ө.Шижир гишүүний микрофон. Д.Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

Өргөдлөө өгч байгаа Н.Учрал даргаас асуух асуулт байхгүй. Асуугаад хариулт нь ямар ч үр дүнгүй байдаг учраас асуулт байхгүй. Асуулт, үг хоёр хамт явж байгаа учраас үг хэлье.

Ингээд улс төрийн шийдвэр гарсан гээд сая Та хэлж байна. Тийм ээ.

Тэгээд танай нам дээр улс төрийн шийдвэр гардаг. Тэр улс төрийн шийдвэрийг дагадаг ийм тогтолцоо байна.

Өчигдөр ажиглаж байхад манай Монгол Ардын нам бол авлигатай эвлэрдэггүй нам гэж хэвлэл мэдээллээр гарч байна л даа.

Авлигатай эвлэрэхгүй байх нь битгий хэл эвлэл нь нэгдээд, схем зураад, одоо энэ схемээ задалж уншиж чадахаа больчихсон юм биш үү? Тийм л байгаа шүү дээ.

Нөгөө бага байхад хүүхдүүд нэг айл гэр болж тоглодог. Тийм ээ. Тэр бол зүгээр тоглоом байсан. Тоглоом байдаг. Дуртай үедээ айл гэр болоод л, тэрийгээ нураагаад л, салаад л, нийлээд л тоглодог. Яг ийм л дүр зураг харагдаж байна шүү дээ.

Тэгээд схемээ задалж уншиж чадахгүй. Тэгээд энэ ард түмнээр тоглоод. Дээрээс нь авлигалтай, хулгайтай эвлэрдэггүй гээд.

→ Хэн энэ авлигалыг хийгээд байгаа юм?

→ Хэн энэ хулгайг хийгээд байгаа юм?

— Ард түмэн лав авлигал аваагүй байх.

— Ард түмэн лав хулгай хийгээгүй байх.

Тэгэхээр энэ бол үнэхээр ард түмнээрээ даажигнасан, тоглосон. Үнэхээр энэ Монгол Улсыг сүйрүүлэх ийм л хэмжээнд аваачиж байна шүү дээ.

Тэгэхээр энэ схемээ задалж унших хэрэгтэй гэж бодож байна. Одоо өөр хэлэх үг алга. Үнэхээр.

Ц.Сандаг-Очир: Д.Энхтуяа гишүүн үг хэллээ. Ө.Шижир гишүүн.

Ө.Шижир: Би ер нь нэг асуулттай байгаа.

Намын дарга Ерөнхий сайд болно гээд Улсын Их Хурлынх нь даргынхаа албан тушаалыг голомгүй маягтай өргөлөө гэж ингэж ойлгож байгаа. Нэгдүгээрт.

Саяхан гуравхан долоо хоногийн өмнө байна уу, дөрвөн долоо хоногийн өмнө Хойд Солонгосын супрем удирдагч нь сонгуульд өрсөлдөөд 99.97 хувиар ялсан юм байна лээ.

Тэгээд өчигдөр Монгол Ардын нам 99.93 хувиар яралзтал зуу, зуу хүргээд явчхаж байна л даа.

Тэгээд сүүлийн танай намын 100 жилийн түүхийг яриад яах вэ. Д.Бодоо, С.Данзан, Д.Сүхбаатар гээд.

- Сүүлийн аравхан жилийн хугацаанд намын дарга, Их Хурлын даргаас Миеэгомбын Энхболдыгоо яав?
- Жаргалтулгын Эрдэнэбатыгаа яав?
- Саяхан болсон Л.Оюунэрдэнэ даргыгаа яав?
- Д.Амарбаясгалан дарга аа яав?

90, 90 хувиар, 99, 99 хувиар алгадаж өгч, гуя дээр чинь гуя янзаглуулж явуулчихаад араас чинь хөлд чинь хориотой мэхээр боодогог хүмүүс шүү дээ.

Яг таны хажууд байгаа хүмүүс чинь.

Хоолойг чинь өчих мэхээр боож, ухаан алдуулж, ямбийтал зоддог хүмүүс шүү дээ.

Ийм л нөхцөл байдал бид сүүлийн нэг жил 6 сарын хугацаанд байлаа.

Үүнийг та өөрөө эрхбиш харсан байлгүй дээ. Ер нь тэгээд Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүд бол Үндсэн хуульд тангараг өргөдөг болохоос намын даргад өргөдөггүй юм шүү гэдгийг би танд нэгдүгээрт хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт, танаас би намын даргын гишүүд ганцхан асуулт байна. Өчигдөр бүтэн сайн өдөр танай Бага хурал хуралдлаа.

Тэгээд танай Бага хурлын гадуур –

- 0001 Дорнод аймгийн Засаг даргын машин,
- 0002 иргэдийн Хурлын Засаг даргын машин,
- 0001 Дарханы Засаг даргын машин,
- 5678 Архангай аймгийн Засаг даргын машинууд –

-танай намын байрны гадаа бүтэн эргэлдлээ.

Би тэр хавиар алхаж яваад харлаа. Өчнөөн аймгууд байна.

Намын хуралд яагаад төрийн машиныг унаж ирээд төрийн мөнгөөр бензин хийгээд байгаа юм. Энэ өөрөө ёс зүйн зөрчил мөн үү? Бүтэн сайн өдөр төрийн алба ажиллаагүй. Зөвхөн танай намын бүлэг хуралдсан. Танай намын Бага хурал хуралдсан.

Яагаад төрийн машинаар, төрийн мөнгөөр бензин хийж ирээд намын хуралд оролцоод байгаа юм. Та үүнийг надаа яг намын даргын хувьд хариулаад өгөөч. Надад ганцхан ийм л асуулт байна.

Ц.Сандаг-Очир: Н.Учрал дарга.

Н.Учрал: Хуулийн хүрээнд л үйл ажиллагаагаа явуулж байна.

Нэгэнт Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь олонх болсон намын төлөөллийн төв байгууллага нь Ерөнхий сайдад нэр дэвшигчээ сонгоод, одоо Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх гээд бас товъёо тогтоох гээд хүлээж байгаа ийм цаг үе.

Хэдийгээр Ерөнхий сайдад нэр дэвшээд Их Хуралд ороод сонгогдох эсэх нь тодорхойгүй байгаа хэдий ч бас зарчмын хувьд Улсын Их Хурлынхаа даргын энэ хариуцлагатай албыг хэлж хүлээлгэж өгч байж мэдээж энэ парламентаар хэлэлцэх үйл явц явах нь зөв өө гэж үзсэн.

Энэ утгаараа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байгаа гэдгийг бас Та бүхэндээ хэлье.

Мэдээж сөрөг хүчний зүгээс тавьсан шаардлагууд, энэ 5 нам, эвслээс бүрдсэн парламентыг нэг намын дарга удирдах нь зохимжгүй байна гэдэг ийм л шаардлага тавьсан шүү дээ. Сөрөг хүчнээс.

Тийм ч учраас төрийн ажил цаашдаа тасралтгүй, тогтвортой явагдах ёстой.

Энэ утгаараа намын Бага хурал хуралдаад ийм улс төрийн шийдвэр гаргасан. Хэрхэхийг мэдээж Их Хурал шийднэ.

Өчигдөр олонхыг бүрдүүлж байгаа нам төлөөллийн төв байгууллагынхаа хурлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг дарга, хурлын дарга нар бол улс төрийн албан тушаалтнууд.

Тэгэхээр улс төрийн албан тушаалтнууд учраас мэдээж намынхаа бага хуралд оролцох ёстой. Тэгээд 3 дугаар сарын 01-нд бид албан тушаал, сандал

суудал ярих биш бодлогын хороодынхоо хурлыг сонсож, мөрийн хөтөлбөртөө үнэлгээ дүгнэлт хийсэн.

Олонх болсон нам бол өөрөө засгийг бүрдүүлж байгаагийнхаа хувьд Засгийн газартаа болоод Улсын Их Хурал дахь бүлэгтээ зохих чиглэлүүдийг өгөөд үнэлгээ дүгнэлт хийгээд урагшилж ирсэн. Манай нам бол ийм системтэй нам.

Тэгэхээр энэ зарчмынхаа дагуу бид өчигдөр Бага хурлаа зохион байгууллаа.

Тэгээд аймгийн удирдлагууд Улаанбаатар хотод хуралдаа оролцох гэж ирэхдээ унаж байгаа машинтайгаа л ирнэ шүү дээ. Хуралдаа суугаад өнөөдөр бас энэ чинь нэг дэх өдөр. Улаанбаатар хотод хурал, зөвлөгөөнүүдэд оролцож салбарын хэд хэдэн сайдуудтай уулзаж ажлаа амжуулаад л буцна аа л гэсэн ийм л одоо хүлээлттэй байгаа шүү дээ. Тийм.

Тэгэхээр танай нам ч бай, аль ч нам бай төлөөллийнхөө төв байгууллагын хуралд улс төрийн албан тушаалтнууд нь сууж, мэдээлэл сонсож, бас үүрэг даалгавар, чиглэлийг тэр Бага хурлаасаа авч мөрийн хөтөлбөрөө биелүүлэх чиглэлээр ажилладаг ийм л зарчим шүү дээ.

Тэгэхээр ардчилсан оронд төлөөллийг мэдээж нам нь өөрөө бүрдүүлдэг. Тэгэхээр нам нь өөрөө хариуцлагатай байх ёстой. Тэгж байж цаашаа төр хариуцлагатай ажиллана.

Тийм учраас намын даргын хувьд өчигдөр Бага хурал дээрээ шат шатны албан тушаалтнууддаа, сонгуульт албан тушаалтнууддаа үүрэг даалгавар өгч, хариуцлагатай ажиллахыг сануулж. Ийм л Бага хурал боллоо шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 17. Ц.Идэрбат гишүүнийг нэмээрэй. Д.Энхтуяа гишүүнийг нэмээрэй. 20 гишүүнээс 19 гишүүн дэмжиж, 90 орчим хувь юм байна даа.

85.0 хувиар санал дэмжигдлээ.

“Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя. /алх цохив/

“Ням-Осорын Учралыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол.

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх хэсэгт 1 дэх заалт, 12.3 дахь хэсэг, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгэж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Б.Пүрэвдорж дарга. 20 гишүүнээс 20 гишүүн 100 хувийн ирцтэйгээр дэмжсэн гэж протоколд тэмдэглүүлье.

Монгол Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие танилцуулна.

Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

11.00 цагаас эргээд энэ танхимдаа Эдийн засгийн байнгын хороотой хамтарсан хуралдаан.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 09 цаг 37 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД